

БАТЛАВ.
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

З.БАТБАЯР
2024 оны 07 сарын 02 өдөр

**ГИДРОГЕОЛОГИЙН ДУНД МАСШТАБ (1:200'000) -ЫН ЗУРАГЛАЛЫН
АЖЛЫГ ӨРГӨЖҮҮЛЖ, УСНЫ НӨӨЦИЙН ТАРХАЛТЫГ ТОГТООХ АЖЛЫН
ДААЛГАВАР**

1. Ажлын даалгавар өгөх үндэслэл:	<ul style="list-style-type: none">- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/47 дугаар тушаалаар батлагдсан Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2 дахь заалт;- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт 6.3-ын 6.3.13 дахь заалт;- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6 дугаар зүйлийн 6.3.4 дахь заалт;- Усны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16¹.4.2 дахь заалт;
2. Ажлын зорилго, гарах үр дүн:	<ul style="list-style-type: none">- Өсөн нэмэгдэх усны хэрэглээг тогтвортой эх үүсвэрээр хангахад шаардагдах газрын доорх усны нөөц бүхий талбайнуудыг илрүүлэх;- Гидрогеологийн 1:200'000-ны зураглал хийхээр Улсын хэмжээнд төлөвлөгдсөн талбайн хүрээнд багтаж байгаа L-49-XXI, L-49-XXVII (хагас) хавтгайнуудад газрын доорх усны тархалтын зүй тогтлыг тогтоох;- 2024 онд гидрогеологийн дунд масштабын зураглал хийсэн талбайн хэмжээг 0.5% -аар нэмэгдүүлэх;- Гидрогеологийн зураглалын ажлын талбайн хэмжээнд тархсан төрөл бүрийн чулуулгуудын усжилтийн зэргийг тодорхойлж, эрэл-хайгуулын ажил хийхэд тохиромжтой талбайнуудыг ялгах;-Судалгааны талбай дахь байгалийн баялгийг тооцож, газрын доорх усны таамаг нөөцийг тогтоох;-2024 онд гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдсэн талбайн хэмжээг 0.5% -аар нэмэгдүүлж гидрогеологийн 1:200'000-ны зураглал хийсэн талбайн хэмжээг Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 17.8%-д хүргэсэн байна.
3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:	“Усны нөөц, нуур, гол мөрний менежмент” хөтөлбөрийн зардлаас. 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөг.
4. Захиалагч байгууллага:	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар
5. Судалгааны үе шат:	Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажил.

6. Судалгааны талбайн нэр:	Дорноговь аймгийн Өргөн, Алтанширээ, Их хэт, Дэлгэрэх сумдын нутагт.															
7. Талбайн солбицол:	Хавтгай: L-49-XXI, L-49-XXVII (хагас) <table border="1" data-bbox="655 258 1134 444"> <thead> <tr> <th>№</th> <th>Уртраг</th> <th>Өргөрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>110°00'00"</td> <td>46°00'00"</td> </tr> <tr> <td>2</td> <td>111°00'00"</td> <td>46°00'00"</td> </tr> <tr> <td>3</td> <td>111°00'00"</td> <td>45°00'00"</td> </tr> <tr> <td>4</td> <td>110°00'00"</td> <td>45°00'00"</td> </tr> </tbody> </table>	№	Уртраг	Өргөрөг	1	110°00'00"	46°00'00"	2	111°00'00"	46°00'00"	3	111°00'00"	45°00'00"	4	110°00'00"	45°00'00"
№	Уртраг	Өргөрөг														
1	110°00'00"	46°00'00"														
2	111°00'00"	46°00'00"														
3	111°00'00"	45°00'00"														
4	110°00'00"	45°00'00"														
8. Судалгаа явуулах хугацаа:	Шалгарч гэрээ байгуулснаас хойш 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл. <i>/Тайланг хүлээлгэн өгөх хугацаагаар тооцов. Үр дүнгийн тайланг Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгнө./</i>															
9. Судалгааны ажлын арга зүй, аргачлал, дэс дараалал	Ажлын үе шатууд: <u>Бэлтгэл ажлын үе шат:</u> Судалгааны ажилд шаардлагатай дараах мэдээллүүдийг бэлтгэнэ. Үүнд: -Талбайн хэмжээнд урьд өмнө хийгдсэн геологи, гидрогеологийн хайгуул, зураглалын ажлын тайлан, холбогдох материалууд; -Сансрын болон өндрийн тоон загварын зургууд; -Анхан шатны мэдээлэл, баримтыг цуглуулан, агаар сансрын зурагт тайлал, боловсруулалтыг хийж гидрогеологийн эрлийн шалгуур, шинж тэмдгийг илрүүлэн цаашдын судалгааг төлөвлөх; -Төсөл хэрэгжүүлэх календарчилсан төлөвлөгөө болон төсвийн хуваарь гаргах; -Зураглалын ажлыг явуулах техник хэрэгсэл, хүний нөөцийг бэлтгэх; <u>Хээрийн судалгааны үе шат:</u> -Судалгааны дэвсгэр талбайн хүрээнд геологи-гидрогеологийн маршрут-ажиглалт, уст цэгийн бүртгэлийг явуулж, геоморфологи, структур-тектоникийн байдал геологийн тогтоц, гидрогеологийн байгалийн суурь нөхцөлтэй газар дээр нь нарийвчлан танилцах; -Хээрийн маршрутын ажлыг зураглал хийх талбайн хэмжээ /L-49-XXI, L-49-XXVII (хагас) хавтгай талбайг бүрэн хамруулах/-нд явуулах; -Газрын гадаргуугийн орчин үеийн хотгор, гүдгэрийн дүрс зүйн холбогдох хэмжилт, шаардлагатай бичиглэл, баримтжуулалтыг хийх;															

	<p>-Судалгааны талбай дахь уст цэгийг бүрэн хамруулан гидрогеохимийн дээжлэлтийн ажлыг зохих арга зүй, аргачлалын дагуу гүйцэтгэж, гарсан үр дүнд онолын тайлал, боловсруулалтыг хийх;</p> <p>-Судалгааны талбайд гадаргуугийн геофизикийн судалгааг хийж, гидрогеологийн хөндлөн болон босоо зүсэлт хийж зурагжуулах суурь мэдээллийг цуглуулан газрын доорх усны нөөц бүхий талбайг ялгах;</p> <p><u>Суурин боловсруулалтын үе шат:</u></p> <p>-Нийт талбайн хэмжээнд гидрогеологийн хөндлөн болон босоо зүсэлт хийж зурагжуулна (1:2000, 1:200'000);</p> <p>-Цаашид газрын доорх усны эрэл-хайгуулын ажил хийхэд тохиромжтой талбайнуудыг ялгах;</p> <p>-Хээрийн ажлын баримт материалын зургийг 1:100'000 -ны масштабтай хийх;</p> <p>-1:200'000-ны масштабтай гидрогеологийн зургийг Arc Gis программ ашиглан, зургийн стандартад нийцүүлж бэлтгэх;</p> <p>-Судалгааны талбай дахь байгалийн баялгийг тооцож, газрын доорх усны таамаг нөөцийг тогтоох;</p>
10. Гүйцэтгэгчид тавигдах шаардлага:	<p>-Төслийн удирдагч (зөвлөх гидрогеологич)-1, ахлах гидрогеологич (мэргэшсэн)-1, гидрогеологич-1, геологич-1, газарзүйн мэдээллийн системийн инженер-1, нийт 5 хүн.</p> <p>-Төслийн удирдагч нь газрын доорх усны хайгуул, судалгаа, гидрогеологийн зураглалын чиглэлээр үйлдвэрлэлийн болон мэргэжлийн туршлага, зөвлөх зэрэгтэй, 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна. Гидрогеологичид нь тухайн чиглэлээр ажилласан ажлын туршлагатай байна.</p> <p>-Хээрийн ажлын явц, гүйцэтгэл, арга аргачлалыг хянах зорилгоор 1 удаа хөндлөнгийн хяналт хийх зардлыг гүйцэтгэгч хариуцна;</p>
11. Мөрдөх хууль тогтоомж, стандарт, журам, эрх зүйн орчин:	<p>-Усны тухай хууль;</p> <p>-“Гидрогеологийн 1:200'000 -ны зураглалын аргачлал, үнэлгээний норм, зургийн таних тэмдэг” аргачилсан заавар (2015).</p>
12. Явцын тайлан:	<ul style="list-style-type: none"> - Өмнөх судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулах; - Маршрутын ажлын үр дүн; - Хээрийн ажлын баримт материалын зургийг 1:100'000 -ны масштабын хийсэн зураг;
13. Үр дүнг тайлагнах:	Гидрогеологийн 1:200'000 -ны масштабтай зураг, үр дүнгийн тайланг тайлбар бичгийн хамт дараах

	<p>хавтгайнуудад L-49-XXI, L-49-XXVII (хагас) хийж гүйцэтгэн, Усны нөөцийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, тайланг Усны газрын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх.</p>
--	--